**“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН**

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ТӨМӨРТЭЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН ИЛ УУРХАЙН” 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-013319/
/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2051303/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: ______________________ / Б.ЧАГНААДОРЖ /

“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР ______________________/П.АЛТАНГЭРЭЛ/

2025 ОН

## Гарчиг

1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга....4

*Хүснэгт 1 Төмөртэй уурхайн уулын ажлын гүйцэтгэл 2025.10.28-ны өдрийн байдлаар*....5

Хүснэгт 2 Баяжуулах үйлдвэрийн гүйцэтгэл....5

2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт....6

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт....6

Хүснэгт 3. Зам усалгаа хийсэн байдал....7

2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт....11

Хүснэгт 4. Усны төлбөр төлсөн байдал....15

2.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт....21

Хүснэгт 5. Газрын төлбөр 2025.10.28-ны байдлаар /тайлангийн жил бүрэн төлж барагдуулсан байна/....22

2.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт....22

2.6. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт....23

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт....24

4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт:....25

5.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт....26

6.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт....27

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт....28

7.1 Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих чиглэлийн ажлууд..........32
*Зураг 25. Ажилтнуудын сувилалд үйлчлүүлж буй байдал*................................................................35
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт................................................................36
Хүснэгт 7 . Хог хаягдлын мэдээ. 2025.01.01-2025.11.01......................................................41
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт...................................................................42
10. Аймаг, сумын Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ.............................................45
10.1. Хүдэр сумтай хамтран ажиллах 2025.02.19 №018 2025-05-20/ гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ:..........................................................................................45
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт..............................................................................46
12.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт..............................................47
13. Дүгнэлт..........................................................................................................................48
Хүснэгт 10 Нийт зарцуулсан зардал..........................................................................48
14. Хавсралт:........................................................................................................................49

## 1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга



“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн харьяа Төмөртэй төмрийн хүдрийн ил уурхай нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Баянцагааны 2-р багийн нутагт орщдог. Тусгай зөвшөөрлийн дугаар MV-013319, лицензийн талбайн хэмжээ 1200га юм. Төмөртэй төмрийн хүдрийн ил орд нь төмөр болон авто замаар Улаанбаатар хоттой Дархан хотыг дайрсан замуудаар холбогдоно. Ордын хүдрийн биетийг зүүн хэсэг, баруун хэсэг гэсэн хэсгүүдэд хуваасан ба хүдрийн биетүүд нь нэг хүдрийн бүсэд хамаарагдах ба өөр хоорондоо 2.0-2.5км зайтай оршино. Төмөртэй уурхайг 2010 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр нээж ил уурхайн олборлолтын ажлыг эхлүүлсэн.

Тус уурхай нь ил уурхай, хуурай соронзон баяжуулах үйлдвэр, засварын төв, ажилчдын тосгон, дэд станц зэрэг нэгж хэсгүүдээс бүрдэх бөгөөд жилд 2 сая.тн төмрийн хүдэр олборлож, 2 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай юм. Уурхайд 390 орчим ажилчид 14/14 ээлжийн хуваариар ажиллаж байна.

2025 оны 10 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 719510,2м$^3$ хөрс хуулалт хийн, 687253,6тн хүдэр олборлон, 773104,3 тн хүдэр боловсруулж, 454131,5 тн баяжмал үйлдвэрлэж, уулын ажлын гүйцэтгэл 56 хувьтай байна.

*Хүснэгт 1 Төмөртэй уурхайн уулын ажлын гүйцэтгэл 2025.10.28-ны өдрийн байдлаар*

| | | | |
|---|---|---|---|
| Хөрс хуулалт | Төлөвлөгөө | м3 | 2,051,691 |
| | Төлөвлөгөөний.тод | | 2,394,846 |
| | Статистик | | 1,511,101 |
| | Гүйцэтгэл | | 1,511,101 |
| | Биелэлт | % | 73,6% |
| Хүдэр олборлолт | Төлөвлөгөө | тн | 1,393,530 |
| | Төлөвлөгөөний.тод | | 1,730,000 |
| | Статистик | | 1,547,572 |
| | Гүйцэтгэл | | 1,547,572 |
| | Биелэлт | % | 111% |
| Уулын цул | Төлөвлөгөө | | 2,336,573 |
| | Гүйцэтгэл | $м^3$ | 1,897,994 |
| | Биелэлт | % | 81.2% |

Хүснэгт 2 Баяжуулах үйлдвэрийн гүйцэтгэл

| | | | |
|---|---|---|---|
| Хүдэр баяжуулалт | Төлөвлөгөө | тн | 1,220,046 |
| | Гүйцэтгэл | тн | 1,134,114 |
| | Биелэлт | % | 92.96% |
| Баяжмал үйлдвэрлэл | Төлөвлөгөө | тн | 1,140,474.59 |
| | Гүйцэтгэл | тн | 1,010,576.30 |
| | Биелэлт | % | 89% |

## 2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

### 2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| Өрөмдлөг тэсэлгээ хийх, хөрс хүдэр болон хаягдал ачиж буулгах, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх | Уурхайн дотоод тээврийн зам, талбайг усны машин ашиглаж усалж, чийглэх | Уурхайн болон уурхайн тээврийн зам | тн | 20-40 | Дотоод зардал | Дулааны улиралд хуурайшилт ихтэй үед өдөр бүр хэрэгжүүлнэ | 142 хоногт 1360 удаагийн рейсээр 27325 тн усаар усалж, чийглэх ажил хийж гүйцэтгэсэн байна. |
| Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл нэмэгдэх, агаар дахь тоосны хэмжээ нэмэгдэх | Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарласан тэмдэг тэмдэглэгээний заалтыг чанд мөрдүүлэх, шинээр зам үүсгэхгүй байхад анхаарах. | Уурхайн дотоод тээврийн зам | - | - | Дотоод зардал | тогтмол | Хурдны дээд хязгаар 40км/цаг мөрдөж, шинэ зам үүсгээгүй ажилласан |
| Хог хаягдлаас үүдэлтэй таагүй үнэр, өвчин үүсгэгч агаар орчинд тархах | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, ариутгал хийх | Хогийн цэгүүдийн орчин | - | - | Хог хаягдлын хэсэгт тусгасан | Тогтмол | Хог ачилт бүрийн дараа ариутгал хийдэг /23 удаа/ |
| Агаарын бохирдлын талаархи хяналт мониторинг байнга хийж байх | Агаарын болон орчны бохирдлыг хэмжих дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болох | Уурхайн орчимд | 1 | Иж бүрдэл | 1500,000 | жилдээ | Агаарын бохирдол хэмжих хяналтын багаж худалдан авч өдөр тутмын хяналт тавьж ажиллаж байна. |
| **Нийт** | | | | | **1500,000** | | |

Хүснэгт 3. Зам усалгаа хийсэн байдал

| Сар | Нийт усалсан рейс | Усалгаа хийсэн хоног | Нийт усалсан усны хэмжээ, тн |
|---|---|---|---|
| 4 сар | *96* | *16* | *1925* |
| 5 сар | *338* | *30* | *6775* |
| 6 сар | *315* | *26* | *6300* |
| 7 сар | *336* | *29* | *6725* |
| 8 сар | *161* | *18* | *3225* |
| 9 сар | *98* | *20* | *1975* |
| 10 сар | *16* | *3* | *400* |
| Нийт | ***1360*** | ***142*** | ***27325*** |

*Зураг 1. Зам усалгаа*





Мөн агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайн авто тээврүүдэд хурд хэмжигч суурилуулсан ба хурдны хязгаарыг “Авто самосвалын жолоочийн дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны заавар”-т 40 км/ц-аар тогтоосон байдаг ба уурхайн ХАБ-н инженерүүд өдөр тутам хурданд хяналт тавин ажилладаг. Сар бүр хурдны мэдээллийг гарган илэрсэн зөрчлийн дагуу ажилтнуудын KPI /урамшууллын оноо/–г хасаж хариуцлага тооцдог.





*Зураг 2. Авто самосвалын жолоочийн дагаж мөрдөх аюулгүй ажиллагааны заавар*

Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК | А3
Автосамосвал ашиглах ажлын заавар
ДТҮ- А3/23-05-02-037 Хуудас 12 | 20

3.4.4.8 Налуу замд гулгаа үүссэн бол тохирох араанд түгжиж явна

3.4.4.9 Ачаатай өгсөх үедээ автосамосавлын хүч алдуулахгүйн тулд тухайн замын нөхцөлийг үнэлэн тохирох араанд түгжих.

3.4.4.10 Тээвэрлэлтийн замд автосамосвал хоорондын зай багадаа 50 метр байх ба үзэгдэх орчин хязгаарлагдмал үед үүнээс 2 дахин илүү зай барьж явна.

3.4.4.11 Зам дээр ажиллаж байгаа болон зорчиж байгаа зам усалгааны автосамосвал, автогрейдер, гинжит механизм, эвдэрсэн техникийн дэргэдүүр өнгөрөх, гүйцэж түрүүлэхдээ операторт радио холбоогоороо мэдэгдэж зэрэг хариу авсны дараа замын бартаа саадгүй, үзэгдэх орчин сайн багаа нөхцөлд гүйцэж түрүүлнэ.

3.4.4.12 Замын тэмдэг тэмдэглэгээг дагаж мөрдөнө. Тэмдэг тэмдэглэгээгүй уулзварт уурхайн замын хөдөлгөөний журмын дагуу уулзварт нэвтрэх дараалльгг баримтлан бусад хөдөлгөөнд оролцогчдодоо хүндэтгэн ажиллана.

3.4.4.13 Уурхайн бүсэд замын хөдөлгөөнд оролцох үеийн хурдны дээд хязгаарыг мөрдөнө. Онцгой тохиолдлуудад доорх хязгааруудыг багасгасан байж болохыг анхаарах.

3.4.4.13.1 Зогсоолын талбай, засварын талбай -10км\ц

3.4.4.13.2 Налуу замд -20км\ц

3.4.4.13.3 Технологийн тээврийн тэгш зам -40км\ц

3.4.4.13.4 **Ачилт, буулгалтын хэсэгт -20км\ц**

3.4.5 **Халтиргаатай замд жолоодох.**

3.4.5.1 Сонор сэрэмжтэй жолоодлого гэдгийг шууд утгаар нь ойлгож болно.

3.4.5.2 Халтиргаа гулгаатай үед хэвгий, налуу газар зорчихгүй байх.

3.4.5.3 Халтиргаа гулгаа ихтэй зам талбайгаар зорчиход эрсдэл өндөр тохиолдолд мастерт мэдээлэлж эрсдэлийг арилгасны дараа зорчих.

3.4.5.4 Автосамосвалыг халтиргаатай нойтон зам дээр жолоодохдоо:

3.4.5.4.1 Автомат удаашруулагч ажиллаж байгаа эсэхийг шалга.

3.4.5.4.2 Урд дугуйн тоормосыг идэвхтэй байгааг шалга.

3.4.5.4.3 Техник хоорондын зай хангалттай эсэхийг шалга.

3.4.5.4.4 Халтиргаатай нөхцөлд автосамосвалын тоормосны зам ихсэх тул эдгээр нөхцөлд хурдаа тохируулж жолоодох.

3.4.6 **Ачаа буулгах.**

3.4.6.1 Ачааг буулгах хэсэгт анхаарал болгоомжтой байж буулгах цэгийг сайтар ажигла. Зөөлөн хөрстэй газраар ухарч ачааг буулгахдаа хамгаалах далангийн наана буулга.

3.4.6.2 Ачааг буулгах үед машиныг тэгш гадаргуу дээр байрлуул

3.4.6.3 Буруу талдаа ("сохор талдаа") өөр техник байгаа тохиолдолд хэзээд бүү ухар

3.4.6.4 Овоолго дээр буулгалт хийхдээ овоолгын ирмэгээс 2 автосамосвалын зайд эргэн овоолгын хагарал цуурал ба хөмсгийг ажиглаж аюулгүй гэж үзвэл тэмдэглэсэн газар бульдозерын операторын зүүн гар талд тэгш талбайг сонгон буулгана.

3.4.6.5 Хэрэв хамгаалалтын далангийн өндөр хангалтгүй хагарал цуурал байвал мастерт мэдэгдэнэ.

3.4.6.6 Маш сайн бэхжилттэй, тэгш гадаргуу дээр автосамосвалыг зүүн гар талаараа овоолгын ирмэг рүү харж тойрсон эргэлт хийж ирмэг рүү 45 градус өнцөг барьж зогсооно. Энэ нь жолоочид ухрах үедээ өөрийн талын дугуй болон өнцгийг байнга сайн харж байх боломжоо олгоно.

Шаардлагатай үед энэхүү аюулгүй ажиллагааны заавар нь хүчинтэй хувилбар мөн эсэхийг баримт бичиг хариуцсан ажилтнаас тодруулна уу

*Зураг 3. Хурд хэтрэлтийн тайлан*

DT631 42-74 ДАУ . 2024 оны 10-р сарын 29 19:45 - 2024 оны 10-р сарын 30 06:45

**Хурд**




**Хурд хэтрүүлэлт (их 40 км/ц дээш хугацаанд 0 мин.)**

| Эхлэх хугацаа | Үргэлжлэх хугацаа | Дундаж хурд, км/ц | Дээд хурд, км/ц | Хаяг |
|---|---|---|---|---|
| **2024 оны 10-р сарын 29 (Мя) : 11** | | | | |
| 20:46:19 | 00:00:09 | 44 | 44 | Худэр |
| 21:32:21 | 00:00:15 | 42 | 42 | Худэр |
| 21:34:21 | 00:00:17 | 44 | 44 | Худэр |
| 21:42:47 | 00:00:19 | 42 | 43 | [ОВТАЛ Зуун/төмөртэй,Хөрс зуун 03/10 Төмөртэй] Худэр |
| 22:02:08 | 00:00:14 | 43 | 44 | Худэр |
| 22:30:24 | 00:00:17 | 47 | 48 | Худэр |
| 22:38:28 | 00:00:10 | 41 | 41 | [ОВТАЛ Зуун/төмөртэй] Худэр |
| 22:56:17 | 00:00:14 | 45 | 45 | Худэр |
| 23:22:09 | 00:00:09 | 41 | 41 | Худэр |
| 23:22:27 | 00:00:09 | 41 | 41 | Худэр |
| 23:31:05 | 00:00:18 | 43 | 44 | [ОВТАЛ Зуун/төмөртэй,Хөрс зуун 03/10 Төмөртэй] Худэр |
| **2024 оны 10-р сарын 30 (Лх) : 17** | | | | |
| 00:29:12 | 00:00:07 | 43 | 43 | Худэр |
| 01:33:57 | 00:00:10 | 43 | 43 | Худэр |
| 01:35:01 | 00:00:36 | 43 | 46 | Худэр |
| 01:36:06 | 00:00:27 | 42 | 43 | Худэр |
| 02:00:59 | 00:00:14 | 44 | 44 | Худэр |
| 02:08:35 | 00:00:10 | 43 | 43 | Худэр |
| 02:10:00 | 00:00:28 | 42 | 42 | Худэр |
| 02:10:57 | 00:00:09 | 42 | 42 | Худэр |
| 02:32:01 | 00:00:09 | 44 | 44 | Худэр |

Хурд хэтрүүлэлтийн тайлан: DT631 42-74 ДАУ. Хуудас 3

*Зураг 4. Техникүүдийн цахим  хяналтын систет*




*Зураг 5. Тоос хэмжих багаж*



## 2.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Too хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Уурхайн ус шүүрүүлэлт, усны хэрэглээнээс газар доорхи усны нөөцийн хомсдол үүсэх | Төрийн байгууллагаар ус ашиглах дүгнэлт гаргуулах, ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх | Усан хангамжийн эх үүсвэр, шүүрлийн ус | - | - | 35.009.404 | | Жилдээ | Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглуулах гэрээ байгуулж 35.009.404 төлбөрийг бүрэн төлсөн |
| | Усыг зүй зохистой хэрэглэх дадлыг хэвшүүлэх талаар сургалт явуулах | | - | - | 200,000 | | Тогтмол | Дэлхийн усны өдрөөр сургалт нөлөөллийг арга хэмжээг ажилчдын дунд зохион байгуулсан |
| | Уурхайн шүүрлийн усыг зам талбайн тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар дахин ашиглах замаар усны нөөцийн хомсдлоос сэргийлэх | | - | - | Дотоод зардал | | Жилдээ | Зам талбайн усалгаа ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна |
| | Цас борооны усыг цуглуулж ногоон байгууламж, мод үржүүлгийн талбайн усалгааны тодорхой хувийг шийдвэрлэх | | - | - | Дотоод зардал | | Жилдээ | Төсөв тооцоолол хийгдсэн. 2026 оны Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан. |
| **Нийт** | | | | | **35.209.404** | | | |

Зураг 6. Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ



Зураг 7.Дэлхийн  усны өдрийг тохиолдуулан сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байуулсан байдал









*Зураг 8. Хараа-Ерөө голын сав газраас гаргасан хаягдал усны дүгнэлт*



ВАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

**ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ**

2025 оны 07 -р сарын 22 -ны өдөр

Дугаар E-2506-000220

Улаанбаатар хот Утас: 265528, 265578

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

**1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:**

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Дарханы төмөрлөгийн үйлдвэр |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 2051303 |
| Захирал: | Чагнаадорж |
| Холбоо барих дугаар:: | 75550011 |

**1.2. Төслийн нэр, байршил:**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Төмрийн хүдрийг ил аргаар олборлох |
| Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт: | Төмөртэй төмрийн хүдрийн уурхай, хуурай соронзон баяжуулах үйлдвэрт боловсруулах. |
| Байршил: | Сэлэнгэ, Хүдэр, 2-р баг, Баянцагаан |
| Дэлгэрэнгүй хаяг: | Сэлэнгэ, Хүдэр, 2-р баг, Баянцагаан, өөрийн байр |
| Харьяалагдах сав газар: | Ерөө голын сав газар |

**Хоёр. Хаягдал усны талаарх мэдээлэл**

**2.1. Хаягдал ус хаях цэгийн байршил, цэвэрлэгээний арга, түвшин**

| | |
|---|---|
| Хаягдал ус нийлүүлэх хэлбэр: | Байгальд нийлүүлэх |
| Нийлүүлж буй хаягдал усны төрөл: | |
| Нэмэлт тайлбар: | АМГТХЭГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэр, ТӨХК-д 13319А тоот тусгай зөвшөөрөлтэй. Төмөртэйн орд. |

**2.2. Хаягдал усны хэмжээ**

| Хаягдал ус нийлүүлэх байгууламж | Хүчин чадал | Хаягдал усны төрөл | Хаягдал ус хаях зайлуулах цэг | Нийлүүлэлт | Цэвэрлэгээний арга | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Унд ахуйн хаягдал ус | 100 м3/хоног | [Унд ахуйн хаягдал ус] | Бохир ус хуримтлуулах цооногт | | Механик, биологи | 15922.5 м3/жил |



БАТЛАВ:
ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
..............................Ө. АРИУНБААТАР

БАТЛАВ:
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР"
ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..............................Б.ЧАГНААДОРЖ

**ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2025 оны 08 сарын 19-ны өдөр № 08 Дархан хот

**Нэг. Ерөнхий зүйл**

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 07 дугаар сарын 22-ний өдрийн E-2506-000220 дугаар хаягдал усны дүгнэлт, Хараа-Ерөө голын сав газрын даргын гаргасан 2025 оны 08 сарын 19-ний өдрийн А/53 тоот хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Хараа-Ерөө голын сав газрын захиргааны мэргэжилтэн Лхагвасүрэн овогтой Насанзул нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Сэлэнгэ аймаг Хүдэр сумын 2-р багт хэрэгжиж буй 1911071815 улсын бүртгэлийн дугаартай, 2051303 тоот регистр, 13319А тусгай зөвшөөрөлтэй, төмрийн хүдрийг ил аргаар олборлох "Төмөртэйн орд" төслийн уурхайн дарга Амар овогтой Ганзориг нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 08 сарын 19-ны өдрөөс эхлэн байгуулав.

**Хоёр. Гэрээний гол нөхцөл**

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал ус, Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.
2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.
2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.
2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:
2.4.1.Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;
2.4.2.Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;
2.4.3.Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;
2.4.4.Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;
2.4.5.Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;
2.4.6.Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Уурхайн кемп болон засварын төвийн ус нь хатуулаг, магнийн агууламж өндөртэй ялангуяа засварын төвийн усны хатуулаг 7мг-экв/л ээс их буюу MNS 9001:2018 "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлттэй байсан тул ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулснаар ажилчид шууд унданд хэрэглэх боломжтой болсон . Ус цэвэршүүлэх төхөөрөмжөөс авсан усны шинжилгээний дүнг "Хавсралт" хэсгээс харна уу.

## Хүснэгт 4.  Усны төлбөр төлсөн байдал

| Дансны хуулга | | | Тайлант үе:   2025/01/01 - 2025/10/31 | |
|---|---|---|---|---|
| **Д/д** | **Огноо** | **Гүйлгээний утга** | **Дебет** | **Үлдэгдэл** |
| Данс: | | Усны татварын өглөг /уурхай/ | | |
| | | Эхний үлдэгдэл: | | |
| 1 | 2025/08/31 | Усны төлбөр 2025-1 | 17,504,702 | 17504 |
| 2 | 2025/10/31 | Усны төлбөр 2025-2 | 17,504,702 | 0 |
| Дт - | 2 | Нийт - 2 ДҮН: | **35,009,404** | |
| | | Эцсийн үлдэгдэл: | | 0.00 |

*Зураг 9. 3 шатлалтай ус тунгаагуурын далан*












## 2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шатах, тослох материал асгарах, гэнэтийн болзошгүй аваар ослоос үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах | ШТС-ын ачаа буулгах түгээх хэсгийн талбайд хайрга дайрга асгаж хөрсөн бүрхэвчийг хамгаалах, хатуу хучилттай эсвэл бетон болгох | ШТС орчим | - | - | 1,500,000 | | Жилд 1 удаа | ШТС-ыг шинээр барих зураг төсөвийг Барилга хөгжлийн төвийн магдалалаар баталгаажуулж тендер зарлагдаад байна. |
| | Шатах тослох материал алдагдах үед яаралтай арга хэмжээ авах асгаралтын иж бүрдэл байршуулах | | ш | 1 | 1.500.000 | | Жилдээ | Асгаралтын иж бүрдэл засавар, уулын хэсэгт тус бүр 2 нийт 4 ширхэгийг худалдан авч байршуулсан |
| Хатуу, шингэн хог хаягдлаар хөрс бохирдох | Хог хаягдлыг төрөлжүүлэн савлаж ангилан ялгах, түр хадгалах цэгт хуримтлуулан зөвшөөрөгдсөн цэгт нийлүүлэх | Төсөл хэрэгжих талбайн хэмжээнд | - | - | Хог хаягдлын менежмент хэсэгт тусгасан | | Тогтмол | Хог хаягдлын менежмент хэсгээс үзэх |
| | Ажилчдын ажлын байрны орчимд эко-жорлон суурьлуулах | Шаардлагтай зарим цэгүүдэд | ш | 2 | 4,000,000 | | Жилдээ | Баяжуулахын Пүүний орчим, Уулын мастерын байранд нийт 2 био жорлон нэмж суурьлуулав. |
| Уурхайн үйл ажиллагааны улмаас хөрс эвдрэх, үржил шим алдагдах, | Хөрсөн бүрхэвчийг талхлагдахаас сэргийлж олон салаа зам үүсгэхгүй байх, нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих | Уурхайн талбайд | - | - | Дотоод зардал | | Жилдээ | Шинэ зам гаргаагүй бөгөөд замын тэмдэг тэмдэглэгээний дагуу зорчиж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| бохирдох | | | | | | | |
| Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх | Хөрс шорооны овоолгыг төлөвлөсөн талбайд эмх цэгцтэй хийх, тэмдэгжүүлэх | Шимт хөрсний овоолго | - | - | Дотоод зардал | Жилдээ | Төлөвлөсөн талбайд овоолго хийж байна. |
| | Өнгөн хөрсийг хуулан авах уурхайн үйл ажиллагаа эхлэх үед өнгөн хөрсийг хуулж, шимт хөрсийг овоолох | | - | - | Дотоод зардал | Тухай бүр | Шимт хөрсийг хуулж овоолго үүсгэж байна. 2025 онд 18000м3 шимт хөрсний овоолго үүсгэсэн. |
| Хөрс бохирдуулах | Асгаралтыг удирдах хэрэгсэлийг нэмэгдүүлэх | Уурхайн талбай | ш | 4 | 3,600,000 | Тухай бүр | Засварын, уулын хэсэгт тус бүр 2 ширхэгийг худалдан авалт хийж байршуулсан |
| **Нийт** | | | | | **10,600,000** | | |

*Зураг 10 Асгаралын иж бүрдэл, бохирдсон хөрс саармагжуулах талбай*


SPILL KIT


HSCT XXK
АСГАРАЛТЫН
ИЖ БҮРДЭЛ


Бохирдсон хөрс
саармагжуулах
талбай



*Зураг 11. Хог хаягдлыг тээвэрлэх  гэрээ*



**ТАВ. ГЭРЭЭТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ҮР ДҮНГ ХҮЛЭЭЛЦЭХ**

5.1 Гүйцэтгэгч нь Сэлэнгэ аймаг, Хүдэр сум, Төмөртэйн төмрийн хүдрийн ил уурхайн ахуйн хог хаягдлыг тээвэрлэх ажлыг талуудын харилцан тохиролцсон хугацаанд Захиалагч талын өгсөн дуудлагын дагуу цаг алдалгүй очиж ажлыг хийж гүйцэтгэнэ.

5.2 Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаагаа бүрэн хариуцна.

5.3 Гүйцэтгэгч нь хог хаягдлыг төвлөрсөн цэгт нийлүүлнэ.

**ЗУРГАА. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

6.1 Захиалагч нь дараах эрх, үүрэгтэй байна:

6.1.1 Захиалагч нь ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж буйг шалгах, шаардлага тавих, зөрчил дутагдлыг мэдэгдэн засуулах эрхтэй.

6.1.2 Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.

6.1.3 Гүйцэтгэгч талд ажил гүйцэтгэх ажлын талбайг бэлдэж өгнө.

6.1.4 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаяхгүй байх

6.1.5 Өөрийн байгууллагын эргэн тойронд 50 метр зайд тогтмол цэвэрлэгээ хийж, хог хаягдалгүй байлгах

**ДОЛОО. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

7.1. Гүйцэтгэгч дараах эрх үүрэгтэй байна

7.1.1. Энэхүү гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөхийг шаардах эрхтэй.

7.1.2. Гэрээт ажлыг гүйцэтгэх Гүйцэтгэгчийн ажилтан нь дадлага туршлагатай мэргэжлийн хүмүүс байх бөгөөд шаардлагатай ажиллах хүч, материал, тоног төхөөрөмж багаж хэрэгслээр хангагдсан байна

7.1.3. Гүйцэтгэгч тал нь ажил эхлэхийн өмнө Захиалагчийн ХАБЭА-ын инженерээс хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг урьдчилан авсан байна.

7.1.4. Гүйцэтгэгч тал нь ажлын байран дахь аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг чанд мөрдөж, аливаа зөрчлийг бүрэн хариуцаж ажиллана.

7.1.5. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцад Захиалагчийн мөрдөж буй ХАБЭА болон бусад дүрэм журмыг чанд мөрдөж ажиллана.

7.1.6. Гэрээний 7.1.5 дахь заалтыг зөрчсөний улмаас үүссэн аливаа эрсдэлийг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

7.1.7. Ажлын үр дүнд муугаар нөлөөлөх ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон бол захиалагч талд нэн даруй мэдэгдэнэ.

7.1.8. Хог, хаягдлыг цуглуулах, төвлөрсөн цэгт тээвэрлэх, ачиж буулгах ажлыг зохион байгуулна.

**НАЙМ.ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

8.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

8.2 Гүйцэтгэгч байгууллага, ажилтан ажил гүйцэтгэх явцдаа захиалагчид болон гуравдагч этгээдэд хохирол учруулбал учруулсан хохирлыг гүйцэтгэгч тал хариуцна.

**ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ**

9.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болох бөгөөд уг байдлын талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэж харилцан зөвшилцөлд хүрнэ.



БАТЛАВ. "ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЧАГНААДОРЖ

БАТЛАВ. ХҮДЭР СУМЫН "ХҮДЭР ТОХИЖИЛТ" ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Л.АНХБАЯР

**"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ТӨМӨРТЭЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН УУРХАЙН АХУЙН ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

2025 оны 1-р сарын 20-ны өдөр    № 03    Хүдэр сум

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Нэг талаас "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК РД:2051303, түүнийг төлөөлж Төмөртэй төмрийн хүдрийн уурхайн дарга А.Ганзориг /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас Хүдэр сумын Хүдэр тохижилт ОНӨААТҮГ, түүнийг төлөөлж дарга Л.Анхбаяр/цаашид "Гүйцэтгэгч"гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, энэ гэрээгээр төлбөр төлөхтэй үүссэн харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА**

2.1. Ажил эхлэх ба дуусах хугацаа: 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд ажлыг хийж гүйцэтгэнэ.
2.2 Захиалагч 12-24 цагийн өмнө ажлын захиалгыг өгнө.
2.3 Гүйцэтгэгч тал Захиалагч талын өгсөн дуудлагын дагуу 1-2 хоногийн дотор ажлыг гүйцэтгэнэ.

**ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС, БУСАД ТӨЛБӨР**

3.1. Хүдэр сумын ИТХ-ын 2023 оны 08-р сарын 22-ны өдрийн 131 тоот тогтоолыг үндэслэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа чиглэлийн дагуу хог үүсгэсний төлбөрийг сар бүр 150000 /Нэг зуун тавин мянган төгрөг/, хог тээврийн зардлыг 1 рейс нь 200000 /Хоёр зуун мянган төгрөг/ байхаар тооцож "Хүдэр тохижилт" ОНӨААТҮҮГ-ын 151400135150 тоот дансанд тээврийн зардлыг төлөх, хог үүсгэсэн төлбөрийг орон нутгийн Татварын дансанд шилжүүлнэ.
3.2. Дээрх үнэнд НӨАТ орсон ба холбогдох бусад бүх зардал багтсан болно.
3.3. Өмнө нь төлөвлөгдөөгүй, гэрээнд тусгагдаагүй, зайлшгүй нэмж хийх шаардлагатай ажил гүйцэтгэвэл ажлын хөлс, түүнийг төлөх хэлбэр, хугацааг талууд тухайн үед нь харилцан тохиролцоно.

| № | Хог хаягдлыг үүсгэгч | | |
|---|---|---|---|
| | Төлбөрийн ангилал | Хугацаа | Төлөх хэмжээ /төгрөг/ |
| 1 | Хог үүсгэсний төлбөр | Сар бүр тогтмол | 150000 |
| | Тээврийн зардал | 1 рейс | 200000 |

**ДӨРӨВ. ТӨЛБӨР ТӨЛӨХ АЖИЛЛАГАА**

4.1 Захиалагч тал гэрээний 3.1 дэх хэсэгт заасан ажлын төлбөрийг холбогдох ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн тухай ажлын акт, нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.
4.2 Төлбөрийн хэрэгсэл: Бэлэн бусаар



**АРАВ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ**

10.1 Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь талуудын зөвшилцлийн үндсэн дээр зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Уг нэмэлт өөрчлөлт гэрээний салшгүй нэгэн хэсэг болох бөгөөд хуулийн хүчин төгөлдөр байна.

**АРВАН НЭГ. БУСАД ЗААЛТ**

11.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж Гүйцэтгэгч тал ажлыг гүйцэтгэж дуусаж, төлбөр тооцоо дууссанаар дуусгавар болно.
11.2 Талуудын хооронд гэрээний заалтыг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан гарвал эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
11.3 Талуудын хоорондын маргаанаа эвийн журмаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
11.4 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах бол талууд бие биедээ ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
11.5 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр хоёр тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
11.6 Талууд нөгөө талын бичгэн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
11.7 Энэхүү гэрээг Монгол хэлээр 3 /гурав/ хувь үйлдэнэ. Захиалагч тал гэрээний 2 /хоёр/ хувь, Гүйцэтгэгч тал 1/нэг/ хувь хадгалах бөгөөд хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК - ИЙН САНХҮҮ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.Б[illegible]РАХ
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Г.ЖАВХЛАНТӨР
ХЭМАББО[illegible]ТСИЙН ДАРГА:
Н.БАТЦЭНД
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БӨГӨӨД НББХ-ИЙН ДАРГА
Б.МӨНХБАЯР
ТӨМӨРТЭЙ ТӨМРИЙН ХҮДРИЙН УУРХАЙН ДАРГА
А.ГАНЗОРИГ

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХҮДЭР СУМЫН "ХҮДЭР ТОХИЖИЛТ" ОНӨААТҮҮГ-ЫН НЯГТЛАН БОДОГЧ
Т.НЯМГЭРЭЛ

Утас: 85659585
РД:8246203
Имэйл/Вэбхуудас:geelee1102@gmail.com
Харилцах банк: Төрийн банк
Дансны дугаар : 151400135150
Хаяг:Сэлэнгэ аймаг Хүдэр сум. 1-р баг Тарвагатай

Зураг 12 Хог ачиж байгаа байдал





*Зураг 13. Эко жорлон суурьлуулсан  байдал*





*Зураг 14. Замын байдал*





*Зураг 15 Хөрсний овоолго хаягжуулсан байдал*










## 2.4. Газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

| Д/д | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Газрын хэвлийг ашигласан төлбөрийг хугацаанд нь төлөх | Газрын хэвлийг ашигласан төлбөрийн 1,2,3-р улирлын төлбөр нийт **161.494.731** төгрөг төлсөн | Дотоод зардал | Газрын төлбөр төлсөн баримтуудыг Хүснэгт3 хавсаргав |
| **НИЙТ** | | | Дотоод зардал | |

Хүснэгт 5. Газрын төлбөр 2025.10.28-ны байдлаар /тайлангийн жил бүрэн төлж барагдуулсан байна/

<table>
<tr><td colspan="3">Дансны хуулга</td><td colspan="2">Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК</td></tr>
<tr><td colspan="5">Дансны хуулга</td></tr>
<tr><td>Д/д</td><td>Огноо</td><td>Гүйлгээний утга</td><td>Дебет</td><td>Үлдэгдэл</td></tr>
<tr><td>Данс :</td><td>3406-4-1-00-000-000-0-0-00-000-00-001</td><td colspan="3">Газрын төлбөрийн өглөг /Сэлэнгэ/</td></tr>
<tr><td>1</td><td>2025.03.18</td><td>Газрын төлбөр-дэд алба</td><td>33.050.592</td><td></td></tr>
<tr><td>2</td><td>2025.03.18</td><td>Газрын төлбөр-дэд алба</td><td>33.050.592</td><td></td></tr>
<tr><td>3</td><td>2025.06.24</td><td>Газрын төлбөр-дэд алба</td><td>31.797.849</td><td></td></tr>
<tr><td>4</td><td>2025.06.24</td><td>Газрын төлбөр-дэд алба</td><td>31.797.849</td><td></td></tr>
<tr><td>5</td><td>2025.09.05</td><td>Газрын төлбөр-дэд алба</td><td>31.797.849</td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
